



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/06-5-ШТА-НА

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа
Утас: 70483413
Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677
Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Цэцэгмаа
Утас: 99488754
Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn
Аудитор О.Энхтөр
Утас: 95343496
Цахим хаяг: enkhturo@audit.gov.mn

Тайлантай холбоотой мэдээллийг дээрх хаягаар холбогдож авна уу.
2025 он



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ.....	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
БҮЛЭГ 1. ТАЙЛАНТ ОНД ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР 25, ШИЛЖИХ 39 НИЙТ 64 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖИЖ БАЙНА.	6
БҮЛЭГ 3. ТАЙЛАНТ ОНД ХЭРЭГЖИЖ ДУУСАХ 5 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.	7
Орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.....	7
Эрх шилжсэн 5 төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд зураг төсөв, техник шаардлагын дагуу комисс, ажлын хэсэг хүлээн авсан байна.	13
Төсөл, арга хэмжээг хүлээн авахдаа зохиогчийн болон техник хяналтын дүгнэлтийг үндэслэн ашиглалтад хүлээн авсан байна.	16
Тайлант онд хүлээн авсан тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгахдаа нэр төрөл, тоо хэмжээг үндэслээгүй, улсын комисс хүлээн авсан 193.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.	16
ДҮГНЭЛТ:.....	17
ШИЙДВЭР:	17
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР	19
САНАЛД ӨГСӨН ХАРИУ ТАЙЛБАР:.....	20

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ**

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГАА	Говь-Алтай аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
НА	Нийцлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	“Сумын төвийн шинэчлэл” /ГАА, Дэлгэр сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг	7
Зураг 2	“Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3” /ГАА, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг	8
Зураг 3	“Цэцэрлэгийн барилга 100 ор” /ГАА, Халиун сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг	8
Зураг 4	“Цэцэрлэгийн барилга 75 ор” /ГАА, Алтай сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг	9
Зураг 5	“Жишиг гудамж тохижилт” /ГАА, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг 2023 он	9
Зураг 6	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тонхил сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг	10
Зураг 7	“Соёлын төвийн барилга” /Говь-Алтай, Цээл сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг	10
Зураг 8	“Спорт заалны барилга” /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг	11
Зураг 9	“Соёлын төвийн барилгын их засвар” /Говь-Алтай, Хөхморьт сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг	11
Зураг 10	“Дотуур байрны барилга” /Говь-Алтай, Тайшир сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг	11
Зураг 11	“Цээл сумын цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух”	14
Зураг 12	“Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж”	14
Зураг 13	“Ахмадын сувиллын тоног төхөөрөмж”	14
Зураг 14	“Мазаалай театрын тоног төхөөрөмж, дууны техник хөгжим хэрэгсэл”	15
Зураг 15	“Угсардаг лед дэлгэц”	15
Зураг 16	“Аймаг сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж”	15

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Говь-Алтай аймагт хэрэгжих төсөл, арга хэмжээ	5
Хүснэгт 2	Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээ	5
Хүснэгт 3	Он дамжсан дуусаагүй төсөл, арга хэмжээ	6



АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу уг аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилго	“Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх; • Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэх; • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эрх шилжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан аймгийн ЗДТГ, түүний харьяа байгууллагууд болон сумдын ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газруудыг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хамруулан аудит хийж гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй	Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим MNS 6817-8:2020, “Нийцлийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын шалгуур үзүүлэлт	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.



Аудитын баг, бүрэлдэхүүн	- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль - Төсвийн тухай хууль - Төрийн хэмнэлтийн тухай хууль - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль - Барилгын тухай хууль - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль - Шилэн дансны тухай хууль - Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” - Холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актууд Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Цэцэгмаа, аудитор О.Энхтөр нар нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.
--------------------------	--

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Говь-Алтай аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 256,457.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 64 төсөл, арга хэмжээг 92,153.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Үүний 39 хувь буюу 25 төсөл, арга хэмжээ нь шинэ, 61 хувь буюу 39 төсөл, арга хэмжээ нь шилжих төсөл, арга хэмжээ байна.

Нийт төсөл, арга хэмжээний 5.0 хувь буюу 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн ТЭЗ-д шилжүүлсэн бөгөөд үүний 2¹ нь 2020 онд, 1² нь 2021 онд, 1³ нь 2022 онд, 5⁴ нь 2024 оноос хэрэгжиж эхэлсэн байна. Бусад 55 төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх эрх доорх хүснэгтийн дагуу харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчдад байна.

¹ Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/.

Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/

² Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх авто зам, Хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг, Хөгжил хорооллын доод талаас 3, 4 дүгээр гудамжинд хатуу хучилттай авто зам /Говь-Алтай, Есөнбулаг сум/

³ Сумын ЗДТГ-ын дэлгэц /Говь-Алтай, Есөнбулаг/

⁴ Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Говь-Алтай, Баян-Уул сум/

Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Говь-Алтай, Тайшир сум/

Усан бассейны чийрэгжүүлэлтийн төвийн тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг сум/

Говь-Алтай аймгийн Ахмадын сувиллын гал тогооны тоног төхөөрөмж багц

Говь-Алтай аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Мазаалай театрын тоног төхөөрөмж, дууны техник хөгжим аппартур багц

Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Говь-Алтай/

Сумын ЗДТГ-ын дэлгэц /Говь-Алтай, Есөнбулаг/



Хүснэгт 1. “Говь-Алтай аймагт хэрэгжиж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Эрх шилжээгүй		Эрх шилжсэн	
		Шилжих	Шинэ	Шилжих	Шинэ
1	Батлан хамгаалахын сайд		1		
2	Боловсролын сайд	17	2	1	
3	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд		1	1	1
	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга			1	3
4	Зам, тээврийн сайд	1	5	1	
5	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	6	4		1
6	Хууль зүй, дотоод хэргийн сайд		2		
7	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд		1		
8	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	6			
9	Эрүүл мэндийн сайд	3	1		
10	Эрчим хүчний сайд	3	2		
	Дүн	36	19	4	5

Тайлант онд хэрэгжих 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Говь-Алтай аймгийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (хуучин нэрээр) хариуцан хэрэгжүүлсэн байна.

Эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний 5 нь барилга байгууламж, 4 нь тоног төхөөрөмж байгаа бөгөөд тайлант онд 1 барилга байгууламж, 4 тоног төхөөрөмж нийлүүлэх ажил хэрэгжиж дууссан байна.

Хүснэгт 2 “Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээ”

сая.төгрөг

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	2024 онд санхүүжих дүн	2024 онд олгосон санхүүжилт	Барьцаа дансанд
1	XIII.1.1.105	Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/	38.3	0.0	38.3
2	XVI.3.3.5	Усан бассейн чийрэгжүүлэлтийн төвийн тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг сум/	90.0	77.1	4.1
3	XIV.4.3.1.9	Говь-Алтай аймгийн Ахмадын сувиллын гал тогооны тоног төхөөрөмж	10.0	9.5	0.0
4	V.3.3.1	Сумын ЗДТГ-ын дэлгэц /Говь-Алтай, Есөнбулаг/	96.0	89.5	4.7
5	V.3.1.2	Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Говь-Алтай/	100.0	94.9	4.9

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 2014 оны 2, 2018 оны 1, 2019 оны 5, 2020 оны 2, 2021 оны 1, нийт 10 төсөл, арга хэмжээ дуусаагүй, үүнээс 9 төсөл, арга хэмжээ нь 2025 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй байна.



Хүснэгт 3. “Он дамжсан дуусаагүй төсөл, арга хэмжээ”

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжиж эхэлсэн он
1	Сумын төвийн шинэчлэл /ГАА, Дэлгэр сум/	2014 он
2	Цэцэрлэгийн барилга 75 ор /ГАА, Алтай сум/	2019 он
3	Жишиг гудамж тохижилт /ГАА, Есөнбулаг сум/	2019 он
4	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тонхил сум/	2019 он
5	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Цээл сум/	2019 он
6	Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2019 он
7	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Хөхморьт сум/	2020 он
8	Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2020 он
9	Дотуур байрны барилга /Говь-Алтай, Тайшир сум/	2021 он

Шилэн данс: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл⁵, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжин хэрэгжсэн 12,860.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл, арга хэмжээг шилэн дансны цахим сайтад ил тод мэдээлсэн байна.

Удирдлагын систем: Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn веб хуудсыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгохоор арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Говь-Алтай аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг тус цахим системд мэдээлсэн байна.

Өмнөх шийдвэрийн хэрэгжилт: Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар Үндэсний аудитын газарт нэгдсэн тайланд тусгуулах 1 санал, аймгийн Засаг даргад 356.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах 3 албан шаардлага хүргүүлсэн ба шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.

БҮЛЭГ 1. ТАЙЛАНТ ОНД ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР 25, ШИЛЖИХ 39 НИЙТ 64 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖИЖ БАЙНА.

1.1 Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйл⁶-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хэрэгжүүлж буй тул орон нутагт мэдээлэлгүй байна.

⁵ 6.9.Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.

⁶ Төсвийн тухай хуулийн 28.3-т “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэрэгүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг дараах зүйлийг харгалзан тогтооно”



БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУГАЦАА АЛДСАНААС ШАЛТГААЛАН ОН ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БАЙГАА 1 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ЗОГССОН, 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД БАТЛАГДААГҮЙ БАЙНА.

- 2.1 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд тусгасан орон нутагт эрх шилжиж шинээр хэрэгжиж эхэлсэн 2 барилга байгууламж, 1 тоног төхөөрөмж, шилжих 2 барилга байгууламж, 1 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг орон нутагт зохион байгуулсан байна.
- 2.2 Мөн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын XIV.4.3.1.11 дугаартай “Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Мазаалай театрын тоног төхөөрөмж, дууны техник хөгжим аппартур” нийлүүлэх ажлын зөвхөн худалдан авах ажиллагааны эрх шилжин Говь-Алтай аймгийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан байна.
- 2.3 Тайлант онд 1,049.9 сая төгрөгөөр санхүүжих дүнтэй “Ахмадын холбоо, сувиллын барилга” /Говь-Алтай,Есөнбулаг сум/ “Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж” /Говь-Алтай/ төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1⁷-д заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.
- 2.4 Үүнээс шалтгаалан “Ахмадын холбоо, сувиллын барилга” /Говь-Алтай,Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээний тайлант онд батлагдсан 1,000.0 сая төгрөгийн санхүүжилт татагдаж, 2025 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй төсөл, арга хэмжээний хэрэгжилт зогсох үр дагавар үүсжээ.
- 2.5 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын V.3.1.2 дугаартай “Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Говь-Алтай/” төсөл, арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг 4 багцад хувааж 3-д нь шууд худалдан авах гэрээ байгуулж, техник тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс аваагүй байна.

БҮЛЭГ 3. ТАЙЛАНТ ОНД ХЭРЭГЖИЖ ДУУСАХ 5 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.

Орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

- 3.1 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд тусгасан орон нутагт эрх шилжүүлсэн 5 барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчидтэй байгуулсан гэрээний дагуу ажлын гүйцэтгэлээр 2,453.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 2 төсөл, арга хэмжээний санхүүжилт 730.8 сая төгрөгийг Засгийн газрын 2024 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 249 дүгээр тогтоолын 1.3⁸ дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

⁷ батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах

⁸ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт нь батлагдсан, гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн олгох боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах



- 3.2 Гүйцэтгэгчидтэй байгуулсан гэрээний дагуу тоног төхөөрөмж нийлүүлэх 4 ажлыг бүрэн хүлээн авч 271.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- 3.3 Эдгээр тоног төхөөрөмжийн баталгаат болон зүгшрүүлэх тохируулах 1 жилийн хугацаанд гэрээний үнийн дүнгийн 5.0 хувь 13.8 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.
- 3.4 “Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух” /Говь-Алтай, Цээл сум/ төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд хэрэгжин улсын комиссын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ГАА-КД-12/2024 дугаартай актаар хүлээн авсан байна.

Он дамжсан дуусаагүй төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах талаар арга хэмжээ авах шаардлагатай байна.

- 3.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 2014 оны 2, 2018 оны 1, 2019 оны 5, 2020 оны 1, 2021 оны 1, нийт 10 төсөл, арга хэмжээ дуусаагүй, үүнээс 8 төсөл, арга хэмжээ нь 2025 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй байна.
- 3.6 Энэ хугацаанд захиалагч болон техник хяналт хэрэгжүүлэгч байгууллагын ажил хариуцсан албан тушаалтнууд хэд хэдэн удаа солигдсоноос шалтгаалан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаарх зарим баримт материал, мэдээлэл огт байхгүй байна.

Дуусаагүй төсөл, арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

2014 он:

“Сумын төвийн шинэчлэл” /ГАА, Дэлгэр сум/ төсөл, арга хэмжээ нь анх Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XV.1.58-д 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлэхээр тусгагдаж Мандал голомт ХХК-тай гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон боловч хэрэгжиж дуусаагүй байна. Гүйцэтгэгч зуухны барилга, гадна дулааны шугам сүлжээ, гадна холбооны шугам сүлжээний ажлыг гүйцэтгэн хэсэгчлэн комисс ажиллан, ашиглалтад оруулсан. Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил, 0.4 метрийн шугамын эрчим хүчний ажил хийгдээгүй 2024 онд захиалагчийн зүгээс ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Зураг 1. “Сумын төвийн шинэчлэл” /ГАА, Дэлгэр сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг



“Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3” /ГАА, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээ нь анх Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XIX.1.1.24-д 1,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлэхээр тусгагдаж Ус-Алтай ХХК-тай гэрээ байгуулсан боловч ажлаа хугацаандаа гүйцэтгээгүй.

Гүйцэтгэгчид 176.0 сая төгрөгийн санхүүжилт олгож зөвхөн усан оргилуурын суурь цутгах ажлыг хийсэн байна.

Захиалагч талаас хуулийн байгууллагад нэхэмжлэл гарган ГААСДИХАШШ-ийн 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 133/ШШ2018/00567 дугаартай шийдвэрээр дутуу ажлыг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 371 дугаартай албан бичгээр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хандан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.

Зураг 2. “Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3” /ГАА, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг



2018 он:

“Цэцэрлэгийн барилга 100 ор” /ГАА, Халиун сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XIII.1.1.216-д тусгагдан “Баянмогод” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон. Гүйцэтгэгчид 666.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Гүйцэтгэгч ажлаа хугацаандаа гүйцэтгээгүй тул Боловсрол, шинжлэх ухааны яамнаас (хуучин нэрээр) 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 2/4250 дугаартай албан бичгээр гэрээг цуцалсан байна.

Төсөл, арга хэмжээний батлагдсан төсөв 2,000.3 сая төгрөг болж өөрчлөгдөн худалдан авах ажиллагааг 2024 онд дахин зохион байгуулснаар гүйцэтгэгчээр “Модон чөлөө” ХХК шалгарч барилгын ажил 2025 оны 04 дүгээр сард эхэлсэн талаар захиалагчаас албан тоот ирүүлсэн. Энэ төсөл, арга хэмжээ 2025 оны хуульд батлагдсан байна.

Зураг 3. “Цэцэрлэгийн барилга 100 ор” /ГАА, Халиун сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг



2019 он:


“Цэцэрлэгийн барилга 75 ор” /ГАА, Алтай сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XII.1.1.350-д тусгаж, “Си би Ай аутсорс” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон. Гүйцэтгэгчид 420.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын гэрээг 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1/1805 дугаартай албан бичгээр цуцалсан, цутгасан суурин дээр нь барилга барих боломжгүй гэсэн дүгнэлт гарсан байна. 2024 онд 3 удаа тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй байна. Энэ төсөл, арга хэмжээ 2025 оны хуульд батлагдаагүй байна.

Зураг 4. “Цэцэрлэгийн барилга 75 ор” /ГАА, Алтай сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг



“Жишиг гудамж тохижилт” /ГАА, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XI.1.57-д тусгаж, гүйцэтгэгч 2020 онд хэрэгжүүлэн 2021, 2022 онд ажлыг хүлээлгэн өгөхөөр аймгийн ЗДТГ-т хандсан боловч чанар байдал муутай гэх шалтгаанаар захиалагч талаас хүлээж аваагүй байна. Өмнөх аудитаар чанар байдал муутай, бетонон замын зарим хэсэгт хайрга ил гарсан талаар дурдсан ба тайлант онд нэмж ажил хийгдээгүй захиалагчийн зүгээс энэ талаар мэдээлэл байхгүй байна.

Зураг 5. “Жишиг гудамж тохижилт” /ГАА, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг 2023 он



“Соёлын төвийн барилга” /Говь-Алтай, Тонхил сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XII.2.1.53-д тусгаж “Уран-Охид” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон.

Гүйцэтгэгчид 860.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд газар шороо, суурийн ажил, 1 дүгээр давхрын багана, дам нурууны арматурчлал, халаалтын тогооны барилгын газар шороо, суурийн ажил, өрлөгийн ажлыг гүйцэтгэсэн байна. Төсөл, арга хэмжээний хүрээнд 2020 оноос хойш ажил хийгдээгүй ба захиалагч байгууллагаас 2022 оны 5 дугаар сарын 04-

ний өдрийн 354 дүгээр, 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 463 дугаар албан шаардлагуудыг тус тус хүргүүлсэн байна.

Соёлын яамнаас (хуучин нэрээр) 2023 онд гэрээг цуцалж, хуулийн байгууллагад шилжүүлсэн. Зураг төсөвт магадлал хийлгүүлж, дахин тендер зарлахаар шийдвэрлэсэн гэх тайлбарыг ирүүлсэн байна. Энэ төсөл, арга хэмжээ 2025 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй байна.

Зураг 6. Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тонхил сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг



“Соёлын төвийн барилга” /Говь-Алтай, Цээл сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XII.2.1.54-д тусгаж “Уран-Охид” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон. Гүйцэтгэгчид 765.5 сая төгрөгийн санхүүжилт олгож газар шороо, суурийн ажил, 1 дүгээр давхрын баганын арматурчлал, халаалтын тогооны барилгын суурийн ажил, 2 дугаар давхрын арматурчлалын ажлыг хийсэн байна. Зарим баганын хэв хашмалыг буулгаж, дахин хийсэн байна.

Соёлын төвийн барилгын явц 2022-2023 оны хооронд зогссонтой холбоотойгоор Соёлын яамнаас (хуучин нэрээр) гүйцэтгэгчид барилгын төсөл, арга хэмжээний гэрээг 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 3/1877 дугаар албан бичгээр “Гэрээг цуцлах тухай” мэдэгдэл хүргүүлж, гүйцэтгэгч “Уран охид” ХХК нь тус барилгыг 2023 оны 09 сарын 24-ний өдрийн 2023/54 дугаартай актаар Соёлын яамд (хуучин нэрээр) хүлээлгэн өгсөн. Уг барилга дээр дахин тендер зарлаж 2024 оны 10 сард “Зост өргөө” ХХК хүлээн авсан хэдий ч одоогийн байдлаар ажил хийгдээгүй байна. Энэ төсөл, арга хэмжээ 2025 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй байна.

Зураг 7. “Соёлын төвийн барилга” /Говь-Алтай, Цээл сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг



“Спорт заалны барилга” /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XII.3.1.17-д тусгаж “Мөнхөд баярт хөхий” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон. Гүйцэтгэгчид 175.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд 2020 онд газар шороо, суурийн ажил, 2021 онд металл карказыг угсарсан байна.

Биеийн тамир спортын улсын хорооноос 2022 онд “Сонгомол хаус констракшн” ХХК-тай гэрээ байгуулсан. Захиалагч байгууллагаас 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 354 дугаар, 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 457 дугаар, 2022 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 561 дүгээр албан шаардлагуудыг тус тус хүргүүлсэн боловч барилга угсралтын ажлыг эхлээгүй байна. Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тул захиалагчаас гэрээг цуцалсан.

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/13 дугаар захирамжаар гүйцэтгэгч сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиглэлийг аймгийн ЗДТГ-т ирүүлсэн. Худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2024 оны 03 дугаар сард “Хүслэнт хүдэр” ХХК шалгарч гэрээ байгуулсан боловч барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилт татагдсан тул аймгийн Засаг даргын 2024 оны 05 сарын 08-ны өдрийн 2/621 тоот албан бичгээр Сангийн яаманд татан төвлөрүүлсэн дээрх орлогуудыг буцаан орон нутгийн барьцаа дансанд шилжүүлж өгөхийг хүссэн хүсэлтээ Монгол Улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороо болон Сангийн яаманд тус тус хүргүүлсэн байна. Энэ төсөл, арга хэмжээ 2025 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй байна.

Зураг 8. “Спорт заалны барилга” /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг



2020 он:

“Соёлын төвийн барилгын их засвар” /Говь-Алтай, Хөхморьт сум/ төсөл, арга хэмжээг анх Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XIII.1.2.10-д тусган “Аранжин-Алтай” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон. Гүйцэтгэгчид 153.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 355 дугаар, 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 465 дугаар, 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 739 дугаар, 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 822 дугаар албан бичгээр шаардлага хүргүүлсэн. Төсөл, арга хэмжээний хүрээнд 2024 онд захиалагчийн зүгээс ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ төсөл, арга хэмжээ 2025 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй байна.

Зураг 9. “Соёлын төвийн барилгын их засвар” /Говь-Алтай, Хөхморьт сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг



2021 он:

“Дотуур байрны барилга” /Говь-Алтай, Тайшир сум/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр “Чингисийн дуулга констракшн” ХХК-тай 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан боловч ажлыг эхлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-аас 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 2/1073 албан бичгээр гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалсан.

Гүйцэтгэгчээс төсөвт өртөг хүрэлцэхгүй шалтгаанаар өөрийн хөрөнгөөр ажлын зураг төсвийг хийлгэж, магадлалын дүгнэлт гаргуулахаар хүсэлт гаргасныг 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч нар хуралдан хүсэлтийг хүлээн авсан байна. Тус төсөл, арга хэмжээний хүрээнд 2020 оноос хойш ажил хийгдээгүй байна. Энэ төсөл, арга хэмжээ 2025 оны төсвийн тухай хуульд төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.

Зураг 10. “Дотуур байрны барилга” /Говь-Алтай, Тайшир сум/ төсөл, арга хэмжээний явцын зураг



Эрх шилжсэн 5 төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд зураг төсөв, техник шаардлагын дагуу комисс, ажлын хэсэг хүлээн авсан байна.

3.7 Тайлант онд хэрэгжиж байгаа 9 төсөл, арга хэмжээний 2⁹ нь 2020 оноос, 1¹⁰ нь 2021 оноос, 1¹¹ нь 2022 оноос, 5¹² нь 2024 оноос хэрэгжиж эхэлсэн байна.

⁹ Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/.

Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/

¹⁰ Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх авто зам, Хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг, Хөгжил хорооллын доод талаас 3, 4 дүгээр гудамжинд хатуу хучилттай авто зам /Говь-Алтай, Есөнбулаг сум/

¹¹ Сумын ЗДТГ-ын дэлгэц /Говь-Алтай, Есөнбулаг/

¹² Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Говь-Алтай, Баян-Уул сум/

Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Говь-Алтай, Тайшир сум/

Усан бассейны чийрэгжүүлэлтийн төвийн тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг сум/

Говь-Алтай аймгийн Ахмадын сувиллын гал тогооны тоног төхөөрөмж багц

3.8 Дээрх төсөл, арга хэмжээнээс 2024¹³ онд дуусах 5 төсөл, арга хэмжээг зохих журмын дагуу хүлээн авчээ. Тухайлбал:

3.8.1 “Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух” /Говь-Алтай, Цээл сум/ 193.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ гэрээт хугацаанд хэрэгжин улсын комиссын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ГАА-КД-12/2024 дугаартай актаар хүлээн авсан ба магадалшгүй ажлын зардлаас 3 тонн багтаамжтай усны нөөцийн сав авах нэмэлт ажлын хүрээнд гэрээг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хүртэл сунгасан байна.

Зураг 11. “Цээл сумын цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух”



3.8.2 “Усан бассейн чийрэгжүүлэлтийн төвийн тоног төхөөрөмж” /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр “Тото лайтинг сервис” ХХК шалгарч 31 нэр төрлийн 1264 ширхэг 81.8 сая төгрөгийн дасгалын тоног төхөөрөмжийг гэрээний дагуу “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ-т нийлүүлсэн байна.

Зураг 12. “Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж”



3.8.3 “Говь-Алтай аймгийн Ахмадын сувиллын гал тогооны тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч “Алтайн нуруун шонхор” ХХК-иас 13 нэр төрлийн 21 ширхэг 9.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг гэрээний дагуу аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын сувилалд нийлүүлсэн байна.

Говь-Алтай аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Мазаалай театрын тоног төхөөрөмж, дууны техник хөгжим аппаратур багц

Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Говь-Алтай/

Сумын ЗДТГ-ын дэлгэц /Говь-Алтай, Есөнбулаг/

¹³ Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/

Усан бассейн чийрэгжүүлэлтийн төвийн тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг сум/

Говь-Алтай аймгийн Ахмадын сувиллын гал тогооны тоног төхөөрөмж

Говь-Алтай аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Мазаалай театрын тоног төхөөрөмж, дууны техник хөгжим аппаратур

Сумын ЗДТГ-ын дэлгэц /Говь-Алтай, Есөнбулаг/

Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Говь-Алтай/

Зураг 13. “Ахмадын сувиллын тоног төхөөрөмж”



3.8.4 “Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Мазаалай театрын тоног төхөөрөмж, дууны техник хөгжим аппартур” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр “Электрон техник” ХХК шалгарч 18 нэр төрлийн 55 ширхэг 49.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт нийлүүлсэн байна.

Зураг 14. “Мазаалай театрын тоног төхөөрөмж, дууны техник хөгжим хэрэгсэл



Зураг 15. “Угсардаг лед дэлгэц”

3.8.5 “Сумын ЗДТГ-ын дэлгэц” /Говь-Алтай, Есөнбулаг/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр “Лед мастер эвент” ХХК шалгарч 5 нэр төрлийн 154 ширхэг 94.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж түүний дагалдах хэрэгслийг гэрээний дагуу аймгийн Засаг даргын Тамгын газарт нийлүүлсэн байна.



3.8.6 “Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж” /Говь-Алтай/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр “Хансан панзат” ХХК, “Гэгэтэч хаб” ХХК, “Түмэн хишиг өргөө” ХХК- тай гэрээ байгуулан аймгийн Засаг даргын Тамгын газарт 4 нэр төрлийн 10 ширхэг компьютер тоног төхөөрөмж, 2 нэр төрлийн 1,100.0 ширхэг ширээ сандал, Төгрөг сумын засаг даргын Тамгын газарт 8 нэр төрлийн 33 ширхэг тоног төхөөрөмжийг гэрээний дагуу 99.9 сая төгрөгөөр нийлүүлсэн байна.

Зураг 16. “Аймаг сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж”



3.8.7 Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон тоног төхөөрөмжүүд нь сүүлийн үеийн дэвшилтэт технологийг орон нутагт нэвтрүүлсэн иргэд, олон нийтийн чөлөөт цагаа зүй зохистой өнгөрүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн хэрэгцээ шаардлага бүхий хөрөнгө оруулалт болсон байна. Харин аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын сувиллын агуулахад 2.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж хадгалагдаж байгаа нь тухайн төсөл, арга хэмжээний үр өгөөжийг бууруулж байна. Дээрх төсөл, арга хэмжээний хүрээнд 0.4 сая төгрөгийн хуучин зурагт нийлүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээг хүлээн авахдаа зохиогчийн болон техник хяналтын дүгнэлтийг үндэслэн ашиглалтад хүлээн авсан байна.

3.9 Тайлант хугацаанд хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад захиалагчийг төлөөлж аймгийн ЗДТГ-тай байгуулсан гэрээний дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас техник хяналтыг хэрэгжүүлсэн байна. Мөн төсөл, арга хэмжээг хүлээн авахдаа зохиогчийн болон техник хяналтын дүгнэлтийг үндэслэсэн байна.

Тайлант онд хүлээн авсан тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгахдаа нэр төрөл, тоо хэмжээг үндэслээгүй, улсын комисс хүлээн авсан 193.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.

3.10 Тайлант онд эрх шилжин хэрэгжсэн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ нь өөрийн санаачилгаар үнэ дүйцүүлэн сольж авсан 25 килограмм 10 ширхэг гантилыг бүртгэлд дасгалын олс нэрээр тусгасан, мөн 4 нэр төрлийн 74 ширхэг тоног төхөөрөмжийг 1 ширхгээр бүртгэсэн.

3.11 Аймгийн Засаг даргын Тамгын газар “Лед мастер эвент” ХХК-иас нийлүүлсэн 5 нэр төрлийн 154 ширхэг тоног төхөөрөмж түүний дагалдах хэрэгслийг 1 ширхгээр бүртгэсэн нь хөрөнгийн бодит байдлаас зөрүүтэй байна.

3.12 “Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух” /Говь-Алтай, Цээл сум/ төсөл, арга хэмжээ гэрээт хугацаанд хэрэгжин улсын комиссын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ГАА-КД-12/2024 дугаартай актаар хүлээн авсан боловч тус төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 193.7 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагад данс бүртгэлд тусгаагүй байна.



ДҮГНЭЛТ:

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Говь-Алтай аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 25, шилжих 39, нийт 64 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Үүний 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлсэн бөгөөд 5 барилга байгууламж, 4 тоног төхөөрөмж нийлүүлэх ажил байна.
2. Гүйцэтгэлээр тайлант онд 2,453.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 730.8 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилт, 13.8 сая төгрөгийн чанарын баталгаа нийт 744.6 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна.
3. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнээс тайлант онд хэрэгжиж дуусах барилга байгууламжийн 1, тоног төхөөрөмжийн 4 нийт 5 төсөл, арга хэмжээг бүрэн хүлээн авсан байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 2014 оны 2, 2018 оны 1, 2019 оны 5, 2020 оны 1, 2021 оны 1, нийт 10 төсөл, арга хэмжээ дуусаагүй, үүнээс 8 төсөл, арга хэмжээ нь 2025 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй байна.
5. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах хугацаа алдсанаас шалтгаалан он дамжин хэрэгжиж байгаа 1 төсөл, арга хэмжээний хэрэгжилт зогссон, 2025 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй байна. (Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын XIV.5.1.1 дугаартай Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/)

АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2014-2021 ОНД ЭХЭЛСЭН 9 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ДУУСГАХ ТАЛААР ТОДОРХОЙ ҮР ДҮНТЭЙ ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

ШИЙДВЭР:

Аудитын дүгнэлтэд үндэслэн Үндэсний аудитын газарт нэгдсэн тайланд тусгуулах 1 санал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 1 зөвлөмж, аймгийн Засаг даргад 2 зөвлөмж, зөрчил арилгах 2 албан шаардлага, тус тус хүргүүлээ.

Үндэсний аудитын газарт уламжлах санал:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014-2021 онд хэрэгжиж эхэлсэн дуусаагүй 9 төсөл, арга хэмжээг дуусгах ажлыг шийдвэрлүүлэх талаар нэгдсэн тайланд тусгах.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх зөвлөмж:

- Говь-Алтай аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014-2021 онд хэрэгжиж эхэлсэн боловч дуусаагүй 9 төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллах талаар захиалагч яам болон төсвийн ерөнхийлөн захирагч нарт хандах.

Аймгийн Засаг даргад хүргүүлэх зөвлөмж:

- Говь-Алтай аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014-2021 онд хэрэгжиж эхэлсэн дуусаагүй 9 төсөл, арга хэмжээг эрчимжүүлж, ашиглалтад оруулах талаар тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулах.



- Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн тоног төхөөрөмжийг нэр төрлөөр нь данс бүртгэлд тусгах, ашиглалтад тавих дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

Аймгийн Засаг даргад өгөх албан шаардлага:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тухайн оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө зохион байгуулж байх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл, арга хэмжээг хэд хэдэн багц болгон хувааж худалдан авах ажиллагаанаас зайлсхийх зөрчлийг таслан зогсоох



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

Жинст баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82093
Утас/Факс: 7048-4042 Цахим шуудан: info@govi-altai.gov.mn

2025. 04. 21 № 1528

танай _____ -ны № _____ -т

Тайланд санал өгөх тухай

Танай байгууллагаас "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөл болон илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн жагсаалтыг хүлээн авч танилцаад дараах тайлбар, саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Илэрсэн алдаа зөрчлийн бүртгэл жагсаалтын 2-т "Тайлант онд 1049,9 сая төгрөгөөр санхүүжих 2 төсөл арга хэмжээг төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд зохион байгуулаагүй байна" гэж заасан байгаагийн 1 төсөл арга хэмжээ буюу 2020 оноос эхлэн он дамжуулан хэрэгжүүлж буй Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ -ын ажлын үргэлжлэлд 2024 онд санхүүжүүлэхээр батлагдсан 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгийн ажлын тендерийг зохион байгуулах ажил тус аймаг, орон нутгаас шалтгаалаагүй бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 13-нд аймгийн Худалдан авах ажиллагааны газарт цахим системээр эрх шилжин ирсэнтэй холбоотойгоор хуулийн хугацаанд тендерийг зохион байгуулах боломжгүй байсан.

Иймд "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн жагсаалтад заасан дээрх зөрчлийг зөрчлөөс хасуулах саналтай байгаа бөгөөд бусад гарсан зөрчлийг засаж залруулж ажиллах болно.

Хавсралт хуудастай.



Г.ЧИНБАТ



САНАЛД ӨГСӨН ХАРИУ ТАЙЛБАР:

№	Хариу тайлбар	Тайлбар
1	Илэрсэн алдаа зөрчлийн бүртгэл жагсаалтын 2-т “Тайлант онд 1,049.9 сая төгрөгөөр санхүүжих 2 төсөл арга хэмжээг төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд зохион байгуулаагүй байна” гэж заасан байгаагийн 1 төсөл арга хэмжээ буюу 2020 оноос эхлэн он дамжуулан хэрэгжүүлж буй Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ -ын ажлын үргэлжлэлд 2024 онд санхүүжүүлэхээр батлагдсан 1,000.0 (нэг тэрбум) төгрөгийн ажлын тендерийг зохион байгуулах ажил тус аймаг, орон нутгаас шалтгаалаагүй бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 13-нд аймгийн Худалдан авах ажиллагааны газарт цахим системээр эрх шилжин ирсэнтэй холбоотойгоор хуулийн хугацаанд тендерийг зохион байгуулах боломжгүй байсан. Иймд “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн жагсаалтад заасан дээрх зөрчлийг зөрчлөөс хасуулах саналтай байгаа бөгөөд бусад гарсан зөрчлийг засаж залруулж ажиллах болно.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын баримт материалд ирсэн Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 01/1033 дугаар “Хариу хүргүүлэх тухай” албан бичигт Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумд хэрэгжих “Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум / төсөл, арга хэмжээг баталсан байна. Тус төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 21 дүгээр тогтоолын хавсралтаар Говь-Алтай аймгийн Засаг даргад шилжүүлсэн. Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/3467 дугаар албан бичиг, 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03/259 дугаар албан бичиг, 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 02/566 дугаар албан бичгээр тус тус чиглэл өгсөн талаар дурджээ. Иймд гаргасан санал, тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.



ТЭМДЭГЛЭЛ

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.